

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс”-ийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/22/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Чойр хот 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543156 Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn Аудитын менежер: Г.Наранбаяр Утас: 70543179 Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn Аудитор:Б.Анхтуяа Утас:70543179 Цахим хаяг: ankhtuyab@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	16
4.2 Төлбөрийн акт	16
4.3 Албан шаардлага	16
4.4 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	17,045,596.86	33,070,955.61
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	214,990.11	189,412.11
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	214,990.11	189,412.11
31210	Төгрөг	214,990.11	189,412.11
31211	Төрийн сангийн харилцах	214,990.11	0.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	0.00	189,412.11
35	БАРАА МАТЕРИАЛ	16,830,606.75	32,881,543.50
35100	Түүхий эд материал	6,418,755.75	6,207,346.50
35110	Тусгай зориулалттай материал	6,418,755.75	6,207,346.50
35300	Бэлэн бүтээгдэхүүн	2,761,616.00	2,724,420.00
35400	Хангамжийн материал	7,650,235.00	23,949,777.00
35410	Бичиг хэргийн материал	259,600.00	1,623,242.00
35420	Аж ахуйн материал	3,788,435.00	9,248,435.00
35440	Түлш, шатах тослох материал	92,100.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	3,510,100.00	13,078,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	51,879,567.77	91,520,004.73
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	51,879,567.77	91,520,004.73
39200	Биет хөрөнгө	40,969,567.77	80,632,004.69
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	55,280,317.60	106,493,267.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	-16,901,825.80	-30,106,973.66
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,047,083.91	9,780,391.23
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,456,007.94	-5,534,680.48
39300	Биет бус хөрөнгө	10,910,000.00	10,888,000.04
39301	Програм хангамж	110,000.00	110,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-21,999.96
39303	Бусад биет бус хөрөнгө	10,800,000.00	10,800,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	68,925,164.63	124,590,960.34
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	54,386.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	54,386.00
41300	Өглөг	0.00	54,386.00
41360	Бусад өглөг	0.00	54,386.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	54,386.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	68,925,164.63	124,536,574.34
51	Засгийн газрын хувь оролцоо	68,925,164.63	124,536,574.34
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	10,800,000.00	10,800,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	52,935,659.60	108,547,069.31
51210	Өмнөх үеийн үр дүн	29,220,153.58	52,935,659.60
51220	Тайлант үеийн үр дүн	23,715,506.02	55,611,409.71
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,189,505.03	5,189,505.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	68,925,164.63	124,590,960.34

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	266,366,377.24	316,622,397.73
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	37,230,877.24	81,842,297.73

“Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс”-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

120	Нийтлэг татварын бус орлого	37,230,877.24	81,842,297.73
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28,171,000.00	7,457,890.95
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	28,171,000.00	7,457,890.95
120009	Бусад орлого	454,990.11	307,422.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,563,871.63	51,447,584.78
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	7,041,015.50	22,629,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	229,135,500.00	234,780,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	202,334,500.00	216,665,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	202,334,500.00	216,665,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,801,000.00	18,114,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	242,650,871.22	260,680,988.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	242,650,871.22	260,680,988.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	241,846,853.53	258,167,802.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	163,578,077.71	190,490,116.67
210101	Үндсэн цалин	163,578,077.71	161,526,836.67
210102	Нэмэгдэл	0.00	25,522,480.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	3,440,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,952,055.60	25,557,870.91
210201	Тэтгэврийн даатгал	15,249,608.44	17,956,628.91
210202	Тэтгэмжийн даатгал	1,769,500.84	1,966,834.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,348,399.07	1,539,866.00
210204	Ажилгүйдлийн даатгал	325,868.57	369,631.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,258,678.68	3,724,911.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,977,707.00	4,582,486.00
210301	Гэрэл, цахилгаан	326,601.00	357,286.00
210303	Цэвэр, бохир ус	148,706.00	0.00
210304	Байрны түрээс	4,502,400.00	4,225,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,147,053.50	14,082,473.03
210401	Бичиг хэрэг	4,975,051.00	2,007,200.00
210402	Тээвэр, шатахуун	4,072,100.00	873,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,479,042.00	733,137.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	60,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	5,806,818.50	8,289,816.08
210408	Бараа материал акталсны зардал	4,754,042.00	2,119,219.95
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	160,000.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	20,000.00	0.00
210604	Урсгал засвар	140,000.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	938,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	938,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,509,415.75	5,605,080.25
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	308,500.00	1,805,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	756,000.00	0.00

“Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс”-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,444,915.75	3,800,080.25
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,584,543.97	17,849,775.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,477,331.00	4,484,027.33
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	269,500.00	138,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,837,712.97	13,227,147.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	804,017.69	2,513,186.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	155,600.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	155,600.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	648,417.69	2,513,186.01
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	648,417.69	568,301.34
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	1,944,884.67
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	23,715,506.02	55,941,409.71
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	330,000.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	0.00	330,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	23,715,506.02	55,611,409.71
VI-I	Засгийн газрын хувь оролцоо	0.00	0.00
VI-II	Хяналтын бус хувь оролцоо	0.00	0.00

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,800,000.00	0.00	29,220,153.58	40,020,153.58
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,800,000.00	0.00	29,220,153.58	40,020,153.58
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	5,189,505.03	0.00	5,189,505.03
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	23,715,506.02	23,715,506.02
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,800,000.00	5,189,505.03	52,935,659.60	68,925,164.63
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	10,800,000.00	5,189,505.03	52,935,659.60	68,925,164.63
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,800,000.00	5,189,505.03	52,935,659.60	68,925,164.63
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	55,611,409.71	55,611,409.71
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	10,800,000.00	5,189,505.03	108,547,069.31	124,536,574.34

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
	/ төгрөгөөр /		
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	293,292,649.21	301,028,780.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО	63,702,159.10	65,941,258.50
118	Бусад татвар, төлбөр, хураамж	63,702,159.10	65,941,258.50
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	63,702,159.10	65,941,258.50
118001	Улсын тэмдэгтийн хураамж	63,702,159.10	65,941,258.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	454,990.11	307,422.00
120	Нийтлэг татварын бус орлого	454,990.11	307,422.00
120009	Бусад орлого	454,990.11	307,422.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	229,135,500.00	234,780,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	202,334,500.00	216,665,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	202,334,500.00	216,665,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,801,000.00	18,114,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,801,000.00	18,114,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	292,540,359.10	301,054,358.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	292,540,359.10	301,054,358.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	227,968,482.31	232,599,913.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	163,578,077.71	172,191,999.58
210101	Үндсэн цалин	137,069,383.47	125,811,609.14
210102	Нэмэгдэл	23,645,696.24	42,345,590.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,862,998.00	4,034,799.92
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,952,055.60	31,837,400.00
210201	Тэтгэврийн даатгал	15,344,093.51	25,676,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,672,070.08	1,540,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,363,016.05	1,232,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	325,097.81	308,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,247,778.15	3,080,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,977,707.00	4,528,100.00
210301	Гэрэл, цахилгаан	326,601.00	302,900.00
210303	Цэвэр, бохир ус	148,706.00	0.00
210304	Байрны түрээс	4,502,400.00	4,225,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,017,242.00	5,068,799.08
210401	Бичиг хэрэг	2,594,500.00	2,856,042.00
210402	Тээвэр, шатахуун	2,082,100.00	781,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,554,042.00	733,137.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	726,600.00	638,620.08
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,130,400.00	443,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	197,500.00	170,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	416,100.00	100,000.00
210604	Урсгал засвар	516,800.00	173,400.00
2107	Томилолт, зочны зардал	938,000.00	0.00

“Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс”-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	938,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,064,500.00	1,805,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	308,500.00	1,805,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	756,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,310,500.00	16,725,215.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,041,000.00	16,502,615.33
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	269,500.00	222,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,571,876.79	68,454,444.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	155,600.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	155,600.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	64,416,276.79	68,454,444.51
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	648,417.69	568,301.34
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	1,944,884.67
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	63,767,859.10	65,941,258.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	752,290.11	-25,578.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	603,000.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	603,000.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	603,000.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	603,000.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-603,000.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	149,290.11	-25,578.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	65,700.00	214,990.11
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	214,990.11	189,412.11

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	216,665,600.00	216,097,298.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	216,665,600.00	216,097,298.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	216,531,200.00	216,097,298.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	172,192,000.00	172,191,999.58
210101	Үндсэн цалин	125,811,700.00	125,811,609.14
210102	Нэмэгдэл	42,345,600.00	42,345,590.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,034,700.00	4,034,799.92
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,837,400.00	31,837,400.00
210201	Тэтгэврийн даатгал	25,676,800.00	25,676,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,540,200.00	1,540,200.00

“Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс”-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210203	ҮОМШӨ-ний даатгал	1,232,100.00	1,232,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	308,000.00	308,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,080,300.00	3,080,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,528,100.00	4,528,100.00
210301	Гэрэл, цахилгаан	302,900.00	302,900.00
210304	Байрны түрээс	4,225,200.00	4,225,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,068,800.00	5,068,799.08
210401	Бичиг хэрэг	2,855,900.00	2,856,042.00
210402	Тээвэр, шатахуун	781,000.00	781,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	733,200.00	733,137.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	638,700.00	638,620.08
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	869,300.00	443,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	195,900.00	170,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	500,000.00	100,000.00
210604	Урсгал засвар	173,400.00	173,400.00
2107	Томилолт, зочны зардал	8,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	8,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,805,000.00	1,805,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,805,000.00	1,805,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	222,600.00	222,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	222,600.00	222,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	134,400.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	134,400.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	134,400.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	216,665,600.00	216,097,298.66
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	216,665,600.00	216,097,298.66
310001	Улсын төсвөөс санхүүжих	216,665,600.00	216,097,298.66
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	29.00	29.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	0.00	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	14.00	14.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл / төгрөгөөр /
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	18,114,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	18,114,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,169,615.33
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,169,615.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,169,615.33
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,944,884.67
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,944,884.67
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг	1,944,884.67
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	18,114,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,114,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,114,500.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн “Улсын бүртгэлийн хэлтэс”-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгө болон нэмэлт санхүүжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Анхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн “Улсын бүртгэлийн хэлтэс” нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 35 дугаар албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говьсүмбэр аймгийн “Улсын бүртгэлийн хэлтэс”-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь *“Иргэнд суурилсан төрийн бүртгэлийн үнэн зөв ой санамжийг бий болгох, төр иргэнийг холбосон бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, иргэний эрхийг төрийн бүртгэлийн үйлчилгээгээр ханган ажиллах”* юм.

Тайлант хугацаанд байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Тухайлбал: Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” батлагдаж 11 дүгээр сараас эхлэн мөрдөгдөж эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2021 онд харьяа орон нутаг дахь Говьсүмбэр аймгийн “Улсын бүртгэлийн хэлтэс”-ийн санхүүгийн болон шилэн дансны үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн “Улсын бүртгэлийн хэлтэс” нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 242,650.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 2,426.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувиар буюу 1,698.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говьсүмбэр аймгийн “Улсын бүртгэлийн хэлтэс” нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 821,574.4 мянган төгрөгөөр буюу 15.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцоо дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	214.9	189.4	-25.5
Авлага	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	16,830.6	32,881.5	16,050.9
Үндсэн хөрөнгө	51,879.6	91,520.0	39,640.4
Нийт хөрөнгө	68,925.2	124,590.9	55,665.7
Өр төлбөр	0.0	54.4	54.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	68,925.2	124,536.6	55,611.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	68,925.2	124,590.9	55,665.7

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 189.4 мянган төгрөг болж 25.5 мянган төгрөгөөр буурсан нь ахмадын сангийн үлдэгдлийг зарцуулснаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 32,881.5 мянган төгрөг болж 16,050.9 мянган төгрөгөөр өссөн нь УБЕГ-аас шилжүүлсэн 28,175.8 мянга, тооллогоор илэрсэн 491.4 мянга, нийт 28,175.8 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй нэмэгдсэнээс шалтгаалжээ. Даргын тушаалаар 17 нэр төрлийн 2,119.2 мянган төгрөгийн бараа материал акталж, 330.0 мянган төгрөгийн үнэт цаасыг шилжүүлсэн, 17,351.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, нийт 19,800.7 мянган төгрөгийн бараа материал данснаас хасагдсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 110,720.0 мянган төгрөг болж 58,840.0 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан тоног төхөөрөмж нэмэгдсэнээс шалтгаалжээ. Тухайлбал, үндсэн хөрөнгийн данс нь ТӨБЗГ-ын 2021 оны 314 дүгээр тогтоолоор УБЕГ-аас үнэ төлбөргүй хүлээлгэн өгсөн сандал, ширээ, шүүгээ 6,069.8 мянга, дахин үнэлсэн 1,420.0 мянга, ТӨБЗГ-ын 2021 оны А-1/1694 дугаар албан бичгээр Олон усын Койкагийн санхүүжилтээр нийлүүлэгдсэн “Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих” тоног төхөөрөмж 51,212.9 мянга, нийт 58,702.8 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

ТӨБЗГ-ын 2021 оны 314 дүгээр тогтоолоор 2 ширхэг ширээ 4,756.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж нийт 4,756.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан байна.

Өр төлбөр данс 54.4 мянган төгрөгийн гэрэл цахилгааны зардлын үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 124,536.6 мянган төгрөг болж 55,611.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Говьсүмбэр аймгийн “Улсын бүртгэлийн хэлтэс” нь санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 134,613.8 мянган төгрөгөөр буюу 73.9 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 83,474.4 мянган төгрөгөөр буюу 47.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд өөрчлөлт ороогүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 243,161.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 243,161.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 55,520.5 мянган төгрөгөөр бууруулж 187,641.4 мянган төгрөгөөр баталсан байна. Төсөвт 1 удаа өөрчлөлт орж, 29,024.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, 216,665.6 мянган төгрөг батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70406-Улсын бүртгэл, мэдээлэл хөтөлбөрийн “80101-үндсэн үйл ажиллагааны зардал”, “80802-ажил олгогчоос олгох тэтгэмж”, “81501-Ерөнхийлөгчийн сонгууль”, “81549-Ахмадын сан” арга хэмжээг санхүүжүүлэхээр 216,665.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 216,665.6 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 216,665.6 мянга, нийт 216,665.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 216,097.3 мянган төгрөгийг зарцуулж, 568.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 216,097.3 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь эд хогшил худалдан авах зардлыг 425.9 мянга, томилолт зочны зардлыг 8.0 мянга, урсгал шилжүүлэг зардлыг 134.4 мянга нийт 568.3 мянган төгрөгөөр тус тус дутуу /хэмнэсэн/ зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 70406 хөтөлбөрийн 3 арга хэмжээ 568.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас Ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэл ажлын зардалд 18,114.5 нийт 18,114.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс ерөнхийлөгчийн сонгуулийн материалын зардалд 1,784.3 мянга, шатахууны зардалд 810.0 мянга, хоол, томилолтын зардалд 1,553.6 мянга, урамшууллын зардалд 12,021.7 нийт 156,311.4 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1,944.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108, А/111 дүгээр тушаалаар батлагдсан ерөнхий чиглэлд тусгагдсан асуудлыг онцлон авч үзсэн.

3.8 Аудитын гол асуудал

Аудитад нөлөө үзүүлэх онцлох асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Говьсүмбэр аймгийн “Улсын бүртгэлийн хэлтэс” нь 2021 онд нийт 11,903.3 мянган төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 39,808.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 39,808.0 мянган төгрөгийн 7 залруулга, зөрчлийг арилгах 1 албан шаардлага өгсөн бөгөөд албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	1	0.0	1	0.0	-	-	-
Зөвлөмж	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	1	0.0	1	0.0	-	-	-

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

“Говьсүмбэр аймгийн “Улсын бүртгэлийн хэлтэс”-ийн санхүүгийн үйл ажиллагаанд нарийвчлан авч үзэх асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 75,209.2 мянган төгрөгийн 12 алдаа зөрчил илэрснээс, 74,797.9 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчлийг аудитын явцад залруулж, 411.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 2 алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгууд хийгдсэн байна.

- 4.1.1 Завсрын аудитаар төсвийн гүйцэтгэлийн тайланд үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих орлого 1,135.9 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байсныг залруулсан.
- 4.1.2 Завсрын аудитаар НДШ, ХХОАТ-т өр төлбөртэй тайлагнасныг зөвлөмж өгч залруулсан.
- 4.1.3 Завсрын аудитаар нярав үндсэн хөрөнгийн тайланг данс тус бүрээр бэлтгээгүй байсныг зөвлөмж өгч залруулсан.
- 4.1.4 Завсрын аудитаар ур чадварын нэмэгдлийг сар бүр дүгнэсэн боловч удирдлагын шийдвэр гаргалгүй олгосон байсныг зөвлөмж өгч залруулсан.
- 4.1.5 Нийт 54,167.9 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг авлагын дансаар бүртгээгүй байсныг аудитын явцад залруулав.
- 4.1.6 Ахмадын сангийн 307.4 мянган төгрөгийн орлогыг үндсэн бус үйл ажиллагааны орлогоор бүртгээгүй байсныг аудитын явцад залруулав.
- 4.1.7 Үндсэн хөрөнгийг данснаас хасахдаа дахин үнэлгээний хорогдол, дахин ашиглах боломжтой хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож орлогод авахдаа дахин үнэлгээний нэмэгдэл дансанд нийт 6,176.5 мянган төгрөгөөр тус тус бүртгэсэн байсныг аудитын явцад залруулав.
- 4.1.8 Үндсэн хөрөнгийн шинж чанаргүй 170.0 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөд орлогоор бүртгэсэн байсныг аудитын явцад залруулав.
- 4.1.9 Орлого, үр дүнгийн тайланд цалин, хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 8,365.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байсныг аудитын явцад залруулав.

4.2 Төлбөрийн акт

4.2.1 Ээлжийн амралтын олговрыг цалин хөлстэй давхардуулан 411.3 мянган төгрөг /3 хүнд илүү 209.5 мянга, 3 хүнд дутуу 201.8 мянган төгрөг/ олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 1 дүгээр хавсралтын 1, 2 дахь заалтуудыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5-т заасны дагуу төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

4.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлээгүй байна.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Аж ахуйн материалд нэгээс дээш жил ашиглагдах шинж чанартай 9,078.4 мянган төгрөгийн материалыг бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар

зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дахь заалтууд, УСНББОУС 1- Санхүүгийн тайлангийн толилуулга, ХЗДХЯ-ны НБББББ-ийн бараа материалын тусгай бодлого, ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Бараа материалын тайланд материалыг шинж чанараар нь ангилж бүртгэх

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Нэмэлт санхүүжилтийн данснаас эдийн засгийн ангилал бүрээр зарцуулах эрх нээлгэлгүй зөвхөн 1 эдийн засгийн ангиллаар хөрөнгө /4,063.9 мянган төгрөг/ зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 дахь заалтуудыг зөрчсөн, иж бүрэн байх, ангилал батламж мэдэгдлийг хангаж ажиллаагүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулалт хийхдээ эдийн засгийн ангилал тус бүрээр зарцуулах эрх нээлгэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мян төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	12	75,209.2	9	74,797.9	1	411.3	-	-	2	0.0